



МОСТ ФИНТЕК ХХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү баримт бичгээр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах бодлогыг тодорхойлно.
- 1.2. Энэхүү бодлого нь Монгол улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, эрх бүхий байгууллага гаргасан бусад дүрэм журамд үндэслэх бөгөөд уг бодлогыг хэрэгжүүлэх журмыг эдгээр хууль, дүрэмд заасны дагуу тодорхойлно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Компани татвар төлсний дараах цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахдаа дараах зарчмыг баримтална:

2.1.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

2.1.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс илүү байх;

2.1.3. компани эргүүлэн авах үүрэг хүлээсэн үнэт цаасаа бүрэн авсан байх;

2.2. Компани энэ журмын 2.1. дэх хэсэгт заасан шалгуурыг хангасны дараа тухайн жилд ашигтай ажилласан бол тухайн жилийн цэвэр ашгийн 30-50 хувийг ногдол ашгаар хувиарлаж болно.

2.3. Ногдол ашиг тараах хэлбэр ба хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын баталсан журам, зааврыг зөвлөмжийг дагаж мөрдөнө.

2.4. Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг ТУЗ гаргана. Тооцооллыг компанийн санхүү хариуцсан нэгжийн дүгнэлтийг үндэслэн компанийн гүйцэтгэх удирдлагаас санал болгоно.

2.5. Компани нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хууль, холбогдох журамд заасан нөхцөл шаардлагыг хангасан байна.

2.6. ТУЗ-өөс ногдол ашгийг тараах өдрийг тогтоохдоо компанийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан боломжит хугацааг харгалзана.

2.7. Компани нь өөрийн цахим хуудсанд ногдол ашгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг байршуулна.

2.8. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25-аас дээш хувиар багассан тохиолдолд компани нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор зээл авсан бол зээлдүүлэгчид өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

2.9. Хувьцаа эзэмшигчдэд төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг төлбөл зохих өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгаж, ногдол ашиг төлж эхэлсэн улирал болон жилийн эцэст олоогүй байгаа ногдол ашгийг өглөгийн бүртгэлд бүртгэнэ.

ГУРАВ. ХАРИУЦЛАГА.

2.9. Компани нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь тараагаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх ба компанийд учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.